

ТАНИЛЦУУЛГА

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2015 оны нэгдсэн чуулганаар “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийг баталж, түүнд нийцүүлэн 2016 онд Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар “Төрийн цэргийн байгуулал”-тай холбогдох харилцааг хуульчилсан нь цаг үеийн шаардлагад нийцсэн, ач холбогдол бүхий зохицуулалт болсон юм.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ” гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дэх хэсэгт “цэргийн байгууллага” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг” ойлгохоор тус тус заажээ.

Дотоодын цэргийн тухай хуулиар чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан “Төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна”, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт заасан “Мэргэшсэн, тогтвортой байх”, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэгт заасан “Албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах” гэсэн зохицуулалт хангагдах юм.

Хуулийн төслийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулах бөгөөд Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг шинээр тусгасан.

Одоогийн мөрдөгдөж байгаа Дотоодын цэргийн тухай хуулиар чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд цаашид алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Нэг. Дотоодын цэргийн тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдал:

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Дотоодын цэргийн тогтолцоо, алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрдэж, улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаа болон бусад чиг үүргийн хэрэгжилт сайжирна. Тухайлбал:

1.Дотоодын цэргийг “Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлон, дэмжлэг үзүүлэх болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох нэгжтэй байхаар зохицуулна.

2.Дотоодын цэргийн штабыг Дотоодын цэргийг удирдах мэргэжлийн төв байгууллага болгон, штабын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тусгаж, Дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрснөөр тодорхой эрхийг штабын даргад шилжүүлэхээр тусгана.

3.Дотоодын цэргийн алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх хэсэгт заасан “Хот, суурин дотор такси үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих;” гэж, 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт заасан “Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно;” гэж, 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасан “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан нийгмийн баталгааг Дотоодын цэргийн алба хаагчид нэгэн адил эдлүүлэх зохицуулалтыг бий болгоно.

4.Дотоодын цэргийн алба хаагчийг Дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийхийг хориглож, хараат бус байдлаар албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын нэгэн адил алба хаасан хугацааг тооцохдоо ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцохоор хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт:

1.Улсын онц чухал объектод үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэмэлт хүч хэрэгсэл дайчлах, объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, инженер, техникийн хэрэгслийг нэвтрүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилтийг авч ашиглах талаар зохицуулалтыг бий болгоно.

2. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан, шаардлагатай тохиолдолд улсын онц чухал объектоос бусад объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авч, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгана.

3.Улсын онц чухал объектын хамгаалалтад гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг шалгах, зөрчил гаргасан хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, илэрсэн зөрчлийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх зохицуулалтыг бий болгоно.

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 2.8 дахь хэсэгт “Батлан хамгаалахын иргэний болон цэргийн удирдлагын харилцааг хуулиар зохицуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.8 “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд” хэсгийн 76 дугаар зүйлд “Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4.9 дэх хэсэгт заасан “Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зохистой тогтолцоог төлөвшүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.1 дэх хэсэгт “Иргэдэд адил тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтална” гэж, 3.3.2.6 дахь хэсэгт “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заажээ.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Одоогийн мөрдөгдөж байгаа Дотоодын цэргийн тухай хуулиар чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд цаашид алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Нэг. Дотоодын цэргийн тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдал:

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Дотоодын цэргийн тогтолцоо, алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрдэж, улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаа болон бусад чиг үүргийн хэрэгжилт сайжирна. Тухайлбал:

1.Дотоодын цэргийг “Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлон, дэмжлэг үзүүлэх болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох нэгжтэй байхаар зохицуулна.

2.Дотоодын цэргийн штабыг Дотоодын цэргийг удирдах мэргэжлийн төв байгууллага болгон, штабын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тусгаж, Дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрснөөр тодорхой эрхийг штабын даргад шилжүүлэхээр тусгана.

3.Дотоодын цэргийн алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх хэсэгт заасан “Хот, суурин дотор такси үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих;” гэж, 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт заасан “Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно;” гэж, 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасан “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн

цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан нийгмийн баталгааг Дотоодын цэргийн алба хаагчид нэгэн адил эдлүүлэх зохицуулалтыг бий болгоно.

4.Дотоодын цэргийн алба хаагчийг Дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийхийг хориглож, хараат бус байдлаар албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын нэгэн адил алба хаасан хугацааг тооцохдоо ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцохоор хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт:

1.Улсын онц чухал объектод үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэмэлт хүч хэрэгсэл дайчлах, объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, инженер, техникийн хэрэгслийг нэвтрүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилтийг авч ашиглах талаар зохицуулалтыг бий болгоно.

2. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан, шаардлагатай тохиолдолд улсын онц чухал объектоос бусад объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авч, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгана.

3.Улсын онц чухал объектын хамгаалалтад гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгсэлд үзлэх хийх, бичиг баримтыг шалгах, зөрчил гаргасан хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, илэрсэн зөрчлийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх зохицуулалтыг бий болгоно.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1 дэх хэсэгт заасан Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төрөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

Хууль сахиулах байгууллагын алба хаагч нарын нэгэн адил ажиллах нөхцөл баталгаагаар хангах зорилгоор нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих зохицуулалтыг нэмэхээр;

Дотоодын цэргийн тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг, түүний хэрэгжилтийг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаатай уялдуулж, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох өөрчлөлтийг оруулахаар тус тус тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх саналын талаар

Тус хуулийн төсөл батлагдсанаар Дотоодын цэргийн үйл ажиллагаа бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын харилцан, хамтын ажиллагаа жигдэрч, хүний нөөцийн чадавх, удирдлага, зохион байгуулалт, алба хаагчийн эрх зүйн байдал эрс дээшилж бодитой үр дүнд хүрнэ.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар төсвөөс нэмэгдэл зардал гарахгүй бөгөөд нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбоотойгоор нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

№	ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ	
	<u>Дотоодын цэргийн тухай хууль</u> <u>/Нэмэлт/</u>	<u>Дотоодын цэргийн тухай хууль</u> <u>/Өөрчлөлт/</u>
	<p><u>3¹ дүгээр зүйл. Дотоодын цэргийн байгууллага</u> <u>3¹.Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн.</u> <u>2/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:</u> <u>"7.3.Дотоодын цэрэг нь төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх мэргэжлийн нэгжтэй байж болно."</u> <u>3/8 дугаар зүйлийн 8.1.12, 8.1.13, 8.1.14 дэх заалт:</u> <u>"8.1.12.объектод үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт хүч хэрэгсэл дайчлах;</u> <u>8.1.13.дотоодын цэрэг, алба хаагчийн гүйцэтгэх чиг үүргийн хуваарийг тогтоох, зарим чиг үүргийг анги, байгууллага, түүний алба хаагчид гүйцэтгүүлэхээр даалгах;</u> <u>8.1.14.хуульд заасны дагуу алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах;"</u> <u>4/9 дүгээр зүйлийн 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг:</u> <u>"9.3.Дотоодын цэргийн штабын даргаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч, эсхүл цэргийн мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг томилно.</u> <u>9.4.Штабын дарга нь Дотоодын цэргийн командлагчийгтүр эзгүйд түүнийг энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд орлох бөгөөд гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна.</u> <u>9.5.Дотоодын цэргийн командлагч алба хаагч, ажилтныг томилж, чөлөөлөх, цол олгох, сэргээх, бууруулах, хураан авах, ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх, дотоодын цэргийн байгууллагыг төлөөлөх, төсөв, хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах бүрэн эрхээ штабын даргад тушаалаар шилжүүлж болох бөгөөд ийнхүү</u></p>	<p><u>3 дугаар зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</u> <u>1/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт:</u> <u>4.1.1."дотоодын цэргийн алба хаагч" гэж цэргийн тангараг өргөж, дотоодын цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг;</u> <u>2/33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалт:</u> <u>33.1.10.хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг шалгах, гаргасан зөрчлийг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад шилжүүлэх;</u> <u>4 дүгээр зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн дугаарыг "7.4" гэж, 8 дугаар зүйлийн 8.1.12 дахь заалтын дугаарыг "8.1.15" гэж, 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсгийн дугаарыг "9.6, 9.7" гэж,</u> <u>33 дугаар зүйлийн 33.1.11 дэх заалтын дугаарыг "33.1.12" гэж тус тус өөрчилсүгэй.</u> <u>5 дугаар зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын "улсын онц чухал" гэснийг, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн "ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал объектын харуул хамгаалалтад" гэснийг тус тус хассугай.</u> <u>6 дугаар зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.</u></p>

<p><u>шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй."</u></p> <p><u>5/12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг:</u> <u>"12.5.Объектын хамгаалалтад уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний ажиллах хугацааг Дотоодын цэргийн командлагч тогтооно."</u></p> <p><u>6/33 дугаар зүйлийн 33.1.11 дэх заалт:</u> <u>"33.1.11.хот, суурины дотор такси үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих;"</u></p> <p><u>7/33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:</u> <u>"33.3.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуулийн 22, 23, 24, 25, 26, 27, 29, 31, 32, 33, 40, 43, 44, 45 дугаар зүйлд заасан цагдаагийн алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журмыг мөрдөнө."</u></p> <p><u>8/36 дугаар зүйлийн 36.6, 36.7 дахь хэсэг:</u> <u>"36.6.Дотоодын цэргийн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 87.3, 89.2-т заасан баталгаагаар цагдаагийн алба хаагчийн нэгэн адил хангагдана.</u> <u>36.7.Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ."</u></p> <p><u>9/38 дугаар зүйлийн 38.3, 38.4 дэх хэсэг:</u> <u>"38.3.Энэ хуулийн 38.2-т заасан шаардлагын хүрээнд дотоодын цэргийн алба хаагчийн хүнсний болон эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, хамгаалах болон тусгай хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</u> <u>38.4.Улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилт авч болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална."</u></p>	
<p><u>2 дугаар зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "мэргэжлийн" гэсний дараа "төв" гэж нэмсүгэй.</u></p>	